

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт, шим тэжээлийн асуудал хариуцсан шинжээч,
Даваасүрэн Цэндсүрэн

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь	
			1	2	3	4	5	6
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах								
1	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөлтийг шинэчлэн сайжруулна.	Бодлогын шийдэл хувилбар, төлөвлөлтийн төсөл	Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоол	Аймаг, орон нутаг, нийслэлийн түвшинд бодлогын шийдэл хувилбар, дунд хугацааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна.	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын техникийн дэмжлэгтэйгээр Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх бодлогын шийдэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулсан. Уг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр "Нутришн Плас Консалтинг" ХХК, ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургууль, Монголын Хоол зүйчдийн холбооны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%	

					хамтарсан баг шалгарч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн оролцоог хангасан загвар боловсруулах, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт-үнэлгээг хийж, санал, шийдэл боловсруулах, хүүхдийн хоол үйлдвэрлэлийн системийн загвар боловсруулах бодлогын судалгааг хамтран хийж байна. Дээрх бодлогын судалгааны хүрээнд хийж буй ажлын явцыг танилцуулах уулзалт-хурлыг 2 удаа зохион байгуулж, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сайдын зөвлөх, ХХААХҮЯ, БЕГ, НБГ, яамны холбогдох газар, хэлтсийн удирдлага, мэргэжилтнүүд оролцсон. Мөн сургууль, цэцэрлэгийн хүнсний хангамжийн хэрэгцээний судалгаа, тооцоолол, хүнсний хангамжийг сайжруулах чиглэлээр яамнаас хэрэгжүүлж буй	
--	--	--	--	--	--	--

					арга хэмжээний талаарх мэдээлэл болон бусад шаардлагатай тооцоо, судалгааг боловсруулж, хамтран ажилласнаар хүүхдийн хоол, хүнсний хангамжийн сумын түвшинд хоршоог дэмжсэн загварын төслийг боловсруулаад байна. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг хоолны зардлыг бүрэн өртөгөөр санхүүжүүлэх, сургуулийн хоолны газрыг стандартад нийцүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр шинэчлэн боловсруулсан. Хавсралт: 8 файл		
1.2. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах							
2	Боловсролын ерөнхий хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд заасан эрх	Батлагдсан журам	Журмын төсөл	Журмыг хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, олон нийтэд сурталчлан таниулсан байна.	УИХ-аас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг дагаж, Ерөнхий боловсролын сургуулийн хоол	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн

	зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах				үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.5-д Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам”-ыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлахаар туссан. Уг заалтыг үндэслэн “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам”-ыг шинэчлэн боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/178, А/238, А/173 дугаар хамтарсан тушаалаар баталсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дээрх журмыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сангийн 6836	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	---	--	--	--	---	-----------------------------------	---

					дугаарт бүртгэж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Уг журмаар холбогдох төрийн захиргааны байгууллага, Засаг дарга, орон нутгийн боловсрол, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн газраас сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түүний орчин, аюулгүй байдалд хяналт үнэлгээ хийх, удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиг үүрэг, тайлагналт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохицуулахаар заасан. ХХААХҮЯ, ЭМЯ, БЕГ-т батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлсэн. Мөн нийслэл, орон нутгийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд журмын хэрэгжилтийг хангуулах талаар сургалт зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангасан. Уг журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан МУ-ын Шадар сайд, боловсрол, эрүүл мэндийн сайдын хамтран 2022 оны 28/А/108А/180 дугаар тушаалыг хүчингүй		
--	--	--	--	--	---	--	--

					болгох тушаалыг боловсруулж, батлуулсан. Шинээр батлагдсан журам, стандартад нийцүүлэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмын төслийг шинэчлэн боловсруулж, хэлтсийн хурлаар хэлэлцсэн. Журмын төсөлд орон нутгийн боловсролын газраас санал авахаар ажиллаж байна. Хавсралт: 5 файл		
1.3. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах							
3	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл	Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ	Хуулийн үзэл баримтлалын төсөл, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн байна.	“Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” арга хэмжээний хүрээнд ХХААХҮЯ-наас дээрх хуулийн хүнсний хангамжид хамаарах хэсгийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүнгээр хуулийн хэрэгжилт нь хуулийн төслийн үзэл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					баримтлалаар тавьсан зорилгыг хангаж байгаа бөгөөд эрх зүйн 20 орчим бичиг баримт батлагдсан, цаашид хүнсний хангамжийг сайжруулахтай холбоотой хуулийн өөрчлөлтийн төслийг боловсруулах, хоол үйлдвэрлэл явуулах хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх шаардлагатай гэж дүгнэсэн байна. Үнэлгээний дүн, саналд үндэслэн хуульд манай яамнаас хүнсний хангамжийн бодлогын суурь судалгааг хийж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар ХХААХҮЯ-нд хүргүүлж, хамтарсан уулзалтыг 5 удаа зохион байгуулсан бөгөөд ХЗДХЯ-нд хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Үзэл баримтлал нь хууль зүйн үндэслэл, хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээ, зохицуулалт, үр дагавар гэсэн бүтэцтэй бөгөөд дор дурдсан		
--	--	--	--	--	---	--	--

					харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд: - Хуулийг Боловсролын багц хуультай нийцүүлэх, холбогдох төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нэмж тусгах; - Хүнсний хангамжийн хүртээмж, тогтвортой байдлыг хангах, хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, түүнд төр, хувийн хэвшил, орон нутгийн оролцоог уялдуулан хангах, орон нутгийн эрх, үүргийг нэмэгдүүлэх. Энэ хүрээнд хууль, тогтоолын хэрэгжилтийг хангуулахад тавих хөшүүрэг, татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогыг тодорхойлж тусгах, улсын хэмжээнд хүүхдийн хоолны логиستيкийн сүлжээг бий болгох, хүнс ханган нийлүүлэгчийн үүргийг тусгаж оруулсан. - Хүүхдийн хоолны салбарт санхүүгийн олон талт эх үүсвэрийг бий болгох, бэхжүүлэх, хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх; - Салбар хоорондын уялдааг зохицуулах тогтолцоог		
--	--	--	--	--	---	--	--

					бий болгох зэрэг асуудлыг тусгасан.		
1.4. Сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах							
4	Орон нутгийн дэмжлэг, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог хангах замаар хүүхдийн хоол, хүнсний хангамж, хүртээмжийг сайжруулна.	Засгийн газрын хуралдаанд танилцуулна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал	Засгийн газрын 2019 оны 450, 2021 оны 207 дугаар тогтоол, 2022 оны 36, 55 дугаар тэмдэглэл, 2022 оны 498 дугаар тогтоол	Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, эцэг эх, асран хамгаалагч хариуцах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна.	1. Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2475 төгрөгөөр тогтоосон бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны А/166/559/222 дугаар хамтарсан тушаалаар баталсан хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалтаар тооцоход энэ нь авах шаардлагатай илчлэг, шим тэжээлийн 51%-ийг хангаж байсан. Хоолны зардлыг нэмэгдүүлэх тооцоолол, төслийг боловсруулж, ЗГ-ын 2024.05.29-ний өдрийн 237 дугаар тогтоолоор дээрх зардлыг 525 төгрөгөөр нэмэгдүүлснээр авах шаардлагатай шим тэжээлийн 60%-ийг авах боломжтой болсон. Үүнд шаардагдах зардлын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					тооцооллыг боловсруулан СХОГ-тай хамтран ажиллаж, 2024 оны төсвийн тодотголд тусгуулсан. Мөн нийслэлийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 1000 төгрөгөөр нэмэгдүүлж, эцэг эх, асран хамгаалагч хариуцахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2024.09.11-ний өдрийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэж, "Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоол батлагдсан. Тогтоолоор зорилтот бүлгийн хүүхдийн хоолны зардлыг төр бүрэн хариуцах бөгөөд хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, эцэг эхийн хяналт, оролцоог хангаснаар хүүхдийн цэцэрлэгийн хоол, хүнснээс авах шаардлагатай илчлэг, шим тэжээлийн хэмжээ 20 хувиар нэмэгдсэн.	
--	--	--	--	--	--	--

					Хүүхдийн хоолны чанар, ирц, хоолны зардлын тодорхой хэсгийг эцэг эхээс төвлөрүүлэх, зарцуулалтад тавих хяналтыг хувийн хэвшлийн 5 цахим системээр дамжуулан хэрэгжүүлж байна. 2. ЕБС-ийн үдийн хоолны зардлыг 1000 төгрөг, ЕБС, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2000 төгрөгөөр нэмэгдүүлэх тооцооллыг боловсруулж, 2025 оны улсын төсөвт тусган хүргүүлсний дагуу Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдаас санал авахаар хүргүүлээд байна. Тогтоолын төслийг 12 дугаар сардаа багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан. Хавсралт: 6 файл		
5	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд “Өдөр бүр нэг аяга сүү”	Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сургууль, цэцэрлэгийн	-	Нийт сургууль, цэцэрлэгийн 10 хүртэлх хувьд хэрэгжүүлж	Япон улсын ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Ерөнхий боловсролын	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	тоо		эхэлсэн байна.	сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд Дундговь, Өвөрхангай аймаг, нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 6 сургуулийн бага ангийн сурагчдаас авсан хоол тэжээлийн байдлын судалгаагаар “сурагчдын 82.2 хувьд Д амин дэмийн дутал илэрсэн, хоногт авах шаардлагатай кальцийн хэмжээ 2.7 дахин, сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 3.4 дахин бага байгаагаас ясны нягт бага, ясны сийрэгжилт эхэлсэн” гэсэн дүн гарсан. Хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймгийн Засаг даргын хооронд 2024 онд орон нутагт боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээнд “ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийг дэмжсэн “Өглөөний цай” болон “Сүү” хөтөлбөрийг орон нутаг, эцэг эхийн	сар	даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--------------------------	-----	--	----------------	---	-----	--

					оролцоотойгоор төсөв, санхүүжилтийг шийдвэрлэн зохион байгуулах” арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.13-т Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг үдийн сүүгээр хангах “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Дундговь, Говьсүмбэр, Завхан, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий аймаг болон нийслэлийн 173 сургууль, цэцэрлэгийн 53874 хүүхдэд орон нутгийн төсөв болон эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр 7 хоногийн 1-3 өдөрт 120-250 мл сүүг нэмэлтээр өгч байна. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сүүний		
--	--	--	--	--	--	--	--

					хэрэгцээ, зардлын тооцоолол, мэдээллийг боловсруулж, нэгжийн удирдлага, холбогдох газарт танилцуулсан. Дээрх мэдээлэл, санхүүжилтийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулсан. Хавсралт: 2 файл		
3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
6	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Тайлангийн хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгжийн хэмжээнд нэгтгэж, сар тутам болон хагас, бүтэн жилээр цахим системээр тайлагнан ажилласан. Үүнд: - Сар тутам Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгаврын биелэлтийг 13-18 заалтаар; - Хагас болон бүтэн жилээр салбарын 3 хуулийн биелэлтийг 13 заалтаар, УИХ-ын 1 тогтоолын биелэлтийг 9 заалтаар, УИХ-ын Байнгын хорооны 4 тогтоолын хэрэгжилтийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					15 заалтаар, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн биелэлтийг 1 заалтаар, Үндэсний аюулгүй байдлын 1 зөвлөмжийг 1 заалтаар, Засгийн газрын 4 тогтоолын хэрэгжилтийг 5 заалтаар, Засгийн газрын 4 хуралдааны тэмдэглэлийг 6 заалтаар тус тус 100 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.		
7	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.10-т заасан "Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгоно. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана" арга хэмжээний хэрэгжилтийг 4 заалтаар 1-5 сар, хагас жилээр хугацаанд нь 100 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

8	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 1-3, 3-6 настай хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын хэмжээг үндэслэн жил бүр шинэчлэн тогтооно", "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй байна" гэсэн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг хагас жилээр хугацаанд нь бүрэн тайлагнасан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хоёр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	тайлагнах				дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуульд үдийн хоолны үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэх, хоол шим тэжээлийн боловсрол олгох, сургалтын хөтөлбөрт тусгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасны дагуу хэрэгжилтийг хагас жилээр тайлагнасан.	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	-----------	--	--	--	---	--	--

3.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

10	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна.	1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журмыг орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага болон яамны сайтад байршуулж санал авч, нэгтгэн боловсруулж, батлуулсан. 2. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс зохион байгуулсан "Хүн амын хоол тэжээлийн үндэсний 6 дугаар судалгаа"-ны үр дүнгийн хэлэлцүүлэгт оролцож, мэргэжлийн болон салбарын чиглэлээр холбогдох саналыг өгч ажилласан. Үүнд: ерөнхий боловсролын сургуулийн насны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
----	---	-----------------------------------	----------------------------	--	--	---	--

					хүүхдийн судалгааны үр дүнг бага, дунд, ахлах ангиар задлан тусгах, судалгааны дүнг нэгтгэн дүгнэж, шалтгааныг тусгах, хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг тодорхой оруулах, ЗГ-ын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Өдөр бүр нэг аяга сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Д амин дэмээр баяжуулсан сүүг нийлүүлэх талаар тусгах, дээрх амин дэмийн дутлыг бүс, аймгаар задлан тусгах зэрэг саналыг оруулсан. 3. Улсын хэмжээнд ашиглах "Боловсролын сургалтын байгууллагын нэг маягийн зураг төслийн хэлэлцүүлэг"-т оролцож, сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага стандартын хүрээнд зураг төсөлд нэмж тусгах санал өгсөн. 4. ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийсэн хүүхдийн хоол тэжээлийн байдлын 2 дуг "Ерөнхий боловсролын сургуулийн	
--	--	--	--	--	--	--

					үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих" төслийн хүрээнд сурагчдаас авсан хоол шим тэжээлийн байдлын судалгаанд үндэслэн боловсруулсан "Шим тэжээлийн тэнцвэртэй цэс" цахим номыг боловсролын салбарын цахим системд байршуулан мөрдөн ажиллаж байна. 4. УИХ- ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд хүнсний чиглэлээрх мэдээллийг яамны цахим сайтад түгээн ажилласан. 5. ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийсэн хүүхдийн хоол тэжээлийн байдлын 2 дугаар судалгааны тайланг гарын авлага болон цахим хэлбэрээр хүлээн авч, холбогдох газар, нэгжүүдэд хүргүүлсэн. Хавсралт: 3 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль болон салбарын хууль, шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрхэлж буй ажлын чиг үүрэгтэй холбоотой ном, гарын авлагыг судална.	Эрхэлсэн ажлын чиг үүрэгт хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомжийг судлах, мэдээллийн сан бүрдүүлнэ.	2023 оны тайлан	Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр (тоогоор)	Эрхлэх асуудалд хамааралтай болон шинээр батлагдсан хууль, тогтоомж, дүрэм журам, тушаал шийдвэрийн цахим мэдээллийн санг бүрдүүлсэн. Холбогдох хууль тогтоомжийг судалж, албан ажилдаа ашиглаж байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль эрх зүйн баримт бичгийн эмхэтгэлийг боловсруулахаар БЕГ-тай хамтран ажилласан. ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд боловсруулж буй ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогч талуудад злриулсан "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний гарын авлага"-ыг боловсруулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Байгууллагаас зохион байгуулж буй сургалт,	Байгууллага, мэргэжлийн	2023 оны	Байгууллага, мэргэжлийн	Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн цаг	1-р сар, 2-р сар, 3-р сар,	Өөрийн

	мэргэжлийн чиглэлээрх сургалт, мэдээллийн цагт бүрэн хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлнэ.	байгууллагаас зохион байгуулах сургалтад танхимаар болон цахимаар хамрагдана.	тайлан	байгууллагаас зохион байгуулах сургалтад танхимаар болон цахимаар хамрагдаж, сертификат авсан байна.	болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан. Боловсрол, шинжлэх ухааны яам, БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх" төслийн хүрээнд зохион байгуулсан "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний сургагч багш" бэлтгэх 6 өдрийн 30 цагийн сургалтад хамрагдсан. Мөн Тайланд улсад 2024 оны 3 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн Ойн боловсролын сургалт зөвлөгөөнд хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлсэн. Монголын хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн холбооноос зохион байгуулсан "Дэлхийн хүнсний хөгжил, чиг хандлага, хүнсний аюулгүй байдал" сэдэвт цахим сургалтад хамрагдаж, мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлсэн.	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
--	--	---	--------	--	--	--	---

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын удирдлага, зохицуулалт, тайлагналт, шим тэжээлийн асуудал хариуцсан шинжээч, Даваасүрэн Цэндсүрэн /...../ Огноо: